



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 55

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах зарим арга
хэмжээний тухай

Худалдаа, үйлдвэрлэлийн их сургуулийн 2017 оны төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, газар эзэмшилт, худалдан авах ажиллагааны хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн баримтын шалгалтаар нийт 40,5 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Худалдаа, үйлдвэрлэлийн их сургуульд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Худалдаа, үйлдвэрлэлийн их сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч М.Должинд дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг авсны үндсэн дээр хөрөнгө бэлтгэж байх;

2.2.Баянхонгор аймаг дахь салбар сургуулийн газарт хувийн хөрөнгө оруулалтаар зөвшөөрөлгүй баригдсан спорт заалны асуудал болон Монгол Улсын Их Сургуулиас шилжин ирсэн Төв аймгийн Эрдэнэ сумын Харзтай амралтын газрын 10,4 га газраас алдагдсан 4,4 га газрын асуудлыг хууль хяналтын байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

2.3.Монгол Улсын Их Сургуулийн нэр дээр байгаа 14500 м² сургалтын зориулалттай газрыг Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн нэр дээр шилжүүлэх, Баянхонгор аймгийн салбар сургуулийн 2947,0 м² газрыг Төрийн өмчийн хороо /хуучнаар/-ны 2011 оны 52 дугаар тогтоолын 2 дахь заалтыг үндэслэн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх;

2.4.Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй агуулах /казарум/-ын барилгын газрыг гэрчилгээжүүлэх талаар газрын асуудал эрхэлсэн эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлэх, холбогдох арга хэмжээ авах;

2.5.Сургуулийн үндсэн хөрөнгө болох 22 айлын орон сууцны подвалын урд хэсэгт байрлах Гамшгаас хамгаалах хичээлийн танхим болгон тохижуулж сургалтын өрөө болгосон 1 өрөөг төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулах замаар ашиглуулах;


2.6. Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан "Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ыг мөрдлөг болгох.

2.7.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.


0000101

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Б. ГАНБАТ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА



Ц. ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн
55 дугаар тогтоолын хавсралт

Худалдаа, үйлдвэрлэлийн их сургуульд
хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг
арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах нэгж	Мөнгөн дүн /сая төгрөг/, Газрын хэмжээ /м.кв/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн, шууд зарлага болгосон	Захиргаа, удирдлагын хэлтэс	13.1	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх
2	Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны зөрчил	Захиргаа, удирдлагын хэлтэс	27.4	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хууль, холбогдох журмыг мөрдөж хэрэгжүүлэх
	Хэсгийн дүн:		40.5 сая төгрөг	
3	Эзэмшил газартай холбоотой зөрчил	Захиргаа, удирдлагын хэлтэс	121447 м.кв	Эзэмшил газрыг гэрчилгээжүүлэх арга хэмжээ авах, эд хөрөнгийн эрхийн Улсын бүртгэлд бүртгүүлэх
	Хэсгийн дүн:		121447 м.кв	